

**ГХБХБГ-ЫН 03 ДУГААР САРЫН ЭХНИЙ 7 ХОНОГИЙН АЖЛЫН МЭДЭЭЛЭЛ,
СУДАЛГАА**

2019.03.07.

ӨЛГИЙ СУМ

7 хоногийн ажлын товч мэдээлэл	дараагийн 7 хоногт шийдвэрлэвэл зохих асуудал	бусад асуудал
<p>Алтанцөгц сум: Энэ долоо хоногт ЛМ-д даваа гараг үдээс хойш 2-3 цаг сүлжээ орж нэг иргэний материалыг УБ-д илгээж Э дугаар авч гэрчилгээ олгож хувийн хэрэг нээж скайнерлэж ЛМ-д оруулав.</p> <p>Сумын Төвийн үйлчилгээний зориулалтаар газар эзэмшиж байгаа төрийн болон иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэх тухай мэдэгдэх хуудас тарааж гарын үсэг зуруулав. Бас төлбөрийн нэхэмжлэл өгөв.</p> <p>2-р сарын сарын төлөвлөгөөний биелэлт, 3-р сард хийх ажлын төлөвлөгөө гаргаж ТГ-ын даргад батлуулав.</p> <p>2015 онд Трай минерал ХХК-ны бүрдүүлсэн хувийн хэрэгт ямар хүний хувийн хэрэг байгаа тухай 62 хүний жагсаалт гаргаж нүүр хуудсанд хийж байршуулав.</p> <p>Баяннуур сум: Ажлын төлөвлөгөөний дагуу дотоод ажиллаа өдөр бүр хийж гүйцэтгэж байна. Ард иргэд албан байгууллагаас гаргасан өргөдөл, гомдол, санал хүсэлтийг цаг хугацаанд хүлээн авч шийдвэрлэж эзэд нь хариу өгч байна. Газар өмчлөлд холбоотой 12 иргэний материалыг хүлээн авч холбогдох материалыг бүрдүүлж өгсөн. Газар эзэмшилд холбоотой 2 байгууллагын материалыг хүлээн авч бүрдүүлэн Улсын бүртгэлийн хэлтэст илгэж хуулийн дагуу хугацаанд шийдвэрлэсэн. Хадлангийн талбайн 2 иргэний эрх шилжүүлэв. Аймгийн мэргэжил хяналтын улсын байцаагч Жандауренд удирдамжийн дагуу ажлаа шалгуулсан.</p> <p>Толбо сум: Сумын төв болох хөдөө багын иргэдээс ирсэн өргөдлийг хүлээн авч Засаг даргад танилцуулж ажилласан болно.</p> <p>Улаанхус сум: 2 дугаар сарын тайлангаа гаргаад, 3 дугаар сарын төлөвлөгөөгөө батлуулав.</p>	<p>Шийдвэрлэгдэж дуусаагүй байгаа бичиг, өргөдлийг шийдвэрлэх</p>	

4 иргэнд газар эзэмшлийн гэрчилгээ бичиж шинээр гэрээ байгуулав.

3 иргэнд гарсан сумын Засаг даргын захирамжийг хүчингүй болгох тухай захирамж гаргуулав.

Газар өмчлөлийн гэрчилгээ авахаар хандсан 5 иргэнд сумын Засаг даргын захирамж, хянан баталгаа, кадастрын зураг гэх зэрэг холбогдох бичиг баримтуудыг нь бүрдүүлж өгсөн.

2 иргэнд газрын даамлын тодорхойлолт гаргаж өгөв.

7 иргэнд газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэх тухай сумын засаг даргын захирамж гаргуулав.

Эзэмшүүлсэн газрын хэмжээнд өөрчлөлт орсон нийт 8 иргэнд шинээр сумын засаг даргын захирамж гаргуулав.

Хөх хөтөл багийн төвд хог хаягдлын цэг байгуулах зориулалтаар газар эзэмшлийн захирамж гаргуулав..

Алтай сум: Сумын нутаг дэвсгэрт газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг газрын төлбөрийг хуулийн дагуу ногдуулж сумын төсөвт төвлөрүүлж байна. Эд хөрөнгө, өмчлөх эрхийн гэрчилгээ авахыг хүссэн 1 хүний материалыг бүрдүүлж, кадастрын зураг хийж, аймгийн үл хөдлөх хөрөнгийн газарт хүргүүлсэн. 2 иргэний нэгж талбарын хувийн хэргийг ЛМ2 програмын цахимд архивласан.

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР

2019 ОНЫ 3 ДУГААР САРЫН 01-НИЙ ӨДРИЙН АЙМГИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАРЫН БИЕЛЭЛТ

1. Баяннуур сумын дотуур байрны барилгын зургийг шалгасан 80м гүн худаг гаргахаар төсөв тусгагдсан боловч харамсалтай нөхөр компани гүйцэтгээгүй болно. Шалгалтаар тогтоосон. Үүнийг аймгийн Засаг дарга болон хөрөнгө оруулалтын хэлтсийн даргад танилцуулсан.
2. Сургууль, цэцэрлэгийн худгийн асуудлаар тандалт судалгаа хийж үзэхэд Цэнгэл сумын худгийн асуудлаас 7 нь гүний худагтай, Өлгий сумын 10-р багийн хүүхдийн цэцэрлэгийг ойрхон байгаа гүний худагт холбох боломжтой үлдсэн 14 нь энгийн худаг бөгөөд үүнийг гүний худагтай болгох шаардлагатай байна.